



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2024/192/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Б.Ундаръяа

Утас: 70376994 Цахим хаяг: undariya11@gmail.com

Энэхүү аудитын тайланатй холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	14
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.5.3 Нэмэлт төсөв:	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2. Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуй нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024. 02. 23 № СЭА-2024/192/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 37,597.8 мянган төгрөгийн хими, физикийн кабинетийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, БШУЯ-наас 9,234.3 мянган төгрөгийн ном, ААН-ээс 2,375.0 мянган төгрөгийн ширээ сандал үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 24,133.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 87.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	217,353,226.50	224,178,024.57
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	136,729,918.35	118,332,280.72
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	136,729,918.35	118,332,280.72
31210	Төгрөг	136,729,918.35	118,332,280.72
31211	Төрийн сангийн харилцах	136,729,918.35	118,332,280.72
35	БАРАА МАТЕРИАЛ	80,623,308.15	105,845,743.85
35400	Хангамжийн материал	80,623,308.15	105,845,743.85
35410	Бичиг хэргийн материал	1,615,000.00	1,615,000.00
35420	Аж ахуйн материал	55,960,560.00	55,960,560.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00
35460	Хүнсний материал	315,659.98	4,550,223.58
35470	Бусад хангамжийн материал	19,232,088.17	40,219,960.27
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,586,044,548.37	1,606,193,092.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,586,044,548.37	1,606,193,092.77
39200	Биет хөрөнгө	1,567,796,548.37	1,587,945,092.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,440,491,894.78	1,440,491,894.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	(113501739.57)	(140470199.34)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1666666.68)	(2916666.69)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	201,782,108.43	261,859,495.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	(117756977.36)	(137103979.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,446,300.44	86,961,300.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30373696.29)	(35004254.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	139,384,204.92	139,384,204.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	(51062686.32)	(58986123.42)
39217	Ном	25,053,806.02	28,729,420.02
39300	Биет бус хөрөнгө	18,248,000.00	18,248,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,248,000.00	18,248,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,803,397,774.87	1,830,371,117.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,803,397,774.87	1,830,371,117.34
51	Засгийн газрын хувь оролцоо	1,803,397,774.87	1,830,371,117.34

51100	Засгийн газрын оруулсан капитал	439,352,988.00	439,352,988.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	439,352,988.00	439,352,988.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(261596376.30)	(234623033.83)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2064994151.17)	(261596376.30)
51220	Тайлант үеийн үр дүн	1,803,397,774.87	26,973,342.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,625,641,163.17	1,625,641,163.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,803,397,774.87	1,830,371,117.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,967,640,423.05	1,669,878,786.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,722,326,723.05	60,064,671.32
120	Нийтлэг татварын бус орлого	1,722,326,723.05	60,064,671.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,213,800.00	7,525,798.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4,517,998.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,213,800.00	3,007,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,636,009,212.91	31,551,001.22
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	80,103,710.14	20,987,872.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,245,313,700.00	1,609,814,115.23
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,229,788,700.00	1,420,215,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,229,788,700.00	1,420,215,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,525,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,525,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	189,599,115.23
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	189,599,115.23
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,164,242,648.18	1,642,905,444.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,164,242,648.18	1,642,905,444.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,074,543,650.73	1,548,533,436.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799,517,209.00	1,086,294,541.40
210101	Үндсэн цалин	563,251,796.00	717,705,309.98

210102	Нэмэгдэл	201,523,728.00	307,722,670.40
210104	Урамшуулал	34,741,685.00	60,866,561.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,860,417.60	136,274,507.81
210201	Тэтгэврийн даатгал	71,222,699.63	92,264,939.62
210202	Тэтгэмжийн даатгал	8,715,412.57	10,984,109.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,677,954.48	9,463,523.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,567,667.34	2,633,155.91
210205	Эрүүл мэндийн даатгал	15,676,683.58	20,928,778.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	181,709,115.23
210301	Гэрэл, цахилгаан	0.00	4,862,264.55
210302	Түлш, халаалт	0.00	158,230,050.68
210303	Цэвэр, бохир ус	0.00	18,616,800.00
2105	Нормативт зардал	16,856,981.59	22,114,085.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	16,856,981.59	22,114,085.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	7,890,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	7,890,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,868,150.00	11,249,047.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,643,000.00	4,517,998.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,225,150.00	6,731,049.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,440,892.54	103,002,139.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,895,158.00	28,799,884.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,976,070.00	14,082,798.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,569,664.54	60,119,456.82
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,188,827.45	70,238,667.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,510,170.00	24,133,340.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,803,397,774.87	26,973,342.47
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,803,397,774.87	26,973,342.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,251,527,500.00	1,617,339,913.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,213,800.00	7,525,798.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,213,800.00	7,525,798.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,213,800.00	7,525,798.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4,517,998.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,213,800.00	3,007,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,245,313,700.00	1,609,814,115.23
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,229,788,700.00	1,420,215,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,229,788,700.00	1,420,215,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,525,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,525,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	189,599,115.23
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	189,599,115.23
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,076,192,581.65	1,587,020,550.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,076,192,581.65	1,587,020,550.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	986,362,664.20	1,492,648,543.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799,517,209.00	1,086,294,539.40
210101	Үндсэн цалин	563,251,796.00	717,705,307.98
210102	Нэмэгдэл	201,523,728.00	307,722,670.40
210104	Урамшуулал	34,741,685.00	60,866,561.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,860,417.60	136,383,686.81
210201	Тэтгэврийн даатгал	71,222,699.63	92,607,647.44
210202	Тэтгэмжийн даатгал	8,715,412.57	11,248,697.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,677,954.48	8,883,140.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,567,667.34	2,103,202.67
210205	Эрүүл мэндийн даатгал	15,676,683.58	21,540,998.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	181,709,115.23
210301	Гэрэл, цахилгаан	0.00	4,862,264.55
210302	Түлш, халаалт	0.00	158,230,050.68

210303	Цэвэр, бохир ус	0.00	18,616,800.00
2105	Нормативт зардал	16,930,229.60	22,114,085.00
210502	Хоол, хүнс	16,930,229.60	22,114,085.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	7,890,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	7,890,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,868,150.00	11,249,049.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,643,000.00	4,518,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,225,150.00	6,731,049.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,186,658.00	47,008,066.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,495,158.00	32,925,268.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,691,500.00	14,082,798.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,829,917.45	94,372,007.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,829,917.45	94,372,007.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,319,747.45	70,238,667.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,510,170.00	24,133,340.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	175,334,918.35	30,319,362.37
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	38,605,000.00	48,717,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,605,000.00	48,717,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	38,605,000.00	48,717,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	38,605,000.00	48,717,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(38605000.00)	(48717000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	136,729,918.35	(18397637.63)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	136,729,918.35
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	136,729,918.35	118,332,280.72

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нэээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	439,352,988.00	1,625,641,163.17	(2064994151.17)	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	439,352,988.00	1,625,641,163.17	(2064994151.17)	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,803,397,774.87	1,803,397,774.87
10	2022 оны 12-р сарын 31-нэээрх үлдэгдэл	439,352,988.00	1,625,641,163.17	(261596376.30)	1,803,397,774.87
11	2023 оны 1-р сарын 1-нэээрх үлдэгдэл	439,352,988.00	1,625,641,163.17	(261596376.30)	1,803,397,774.87
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	439,352,988.00	1,625,641,163.17	(261596376.30)	1,803,397,774.87
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	26,973,342.47	26,973,342.47
20	2023 оны 12-р сарын 31-нэээрх үлдэгдэл	439,352,988.00	1,625,641,163.17	(234623033.83)	1,830,371,117.34

2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,754,069,713.23	1,635,737,550.86	118,332,162.37	93.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,754,069,713.23	1,635,737,550.86	118,332,162.37	93.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,754,069,713.23	1,541,365,543.36	212,704,169.87	87.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,160,689,700.00	1,086,294,539.40	74,395,160.60	93.6
210101	Үндсэн цалин	779,841,100.00	717,705,307.98	62,135,792.02	92.0

210102	Нэмэгдэл	315,653,200.00	307,722,670.40	7,930,529.60	97.5
210104	Урамшуулал	65,195,400.00	60,866,561.02	4,328,838.98	93.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,086,400.00	136,383,686.81	8,702,713.19	94.0
210201	Тэтгэврийн даатгал	98,658,800.00	92,607,647.44	6,051,152.56	93.9
210202	Тэтгэмжийн даатгал	11,607,000.00	11,248,697.12	358,302.88	96.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,285,400.00	8,883,140.71	402,259.29	95.7
210204	Ажилгүйдлийн даатгал	2,321,400.00	2,103,202.67	218,197.33	90.6
210205	Эрүүл мэндийн даатгал	23,213,800.00	21,540,998.87	1,672,801.13	92.8
2103	Байр ашиглалттай холбоотой зардал тогтмол	181,709,115.23	181,709,115.23	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	4,862,264.55	4,862,264.55	0.00	100.0
210302	Түлш, халаалт	158,230,050.68	158,230,050.68	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	18,616,800.00	18,616,800.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	22,115,000.00	22,114,085.00	915.00	100.0
210502	Хоол, хүнс	22,115,000.00	22,114,085.00	915.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,890,000.00	7,890,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	7,890,000.00	7,890,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал		0.00	0.00	
210702	Дотоод албан томилолт		0.00	0.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,862,498.00	11,249,049.94	2,613,448.06	81.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,570,798.00	4,518,000.00	52,798.00	98.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,291,700.00	6,731,049.94	2,560,650.06	72.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,710,800.00	95,725,066.98	9,985,733.02	90.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,622,600.00	81,642,268.98	9,980,331.02	89.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,088,200.00	14,082,798.00	5,402.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,006,200.00	94,372,007.50	22,634,192.50	80.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,006,200.00	94,372,007.50	22,634,192.50	80.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	92,847,800.00	70,238,667.50	22,609,132.50	75.6
213209	Нэг удаагийн тэтгэмж,	24,158,400.00	24,133,340.00	25,060.00	99.9

	шагнал урамшуулал				
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,754,069,713.23	1,617,339,913.23	136,729,800.00	92.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,420,215,000.00	1,420,215,000.00	0.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,420,215,000.00	1,420,215,000.00	0.00	100.0
	Орон нутгийн төсөв	189,599,115.23	189,599,115.23		
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	144,255,598.00	7,525,798.00	136,729,800.00	5.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,517,998.00	4,517,998.00	0.00	100.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,007,800.00	3,007,800.00	0.00	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	136,729,800.00	0.00	136,729,800.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	136,729,918.35		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	118,332,280.72		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь “Хүүхэд бүрийн сурч төлөвших нөхцөлийг бүрдүүлж, багш бүрийг хөгжүүлэхэд хамтран ажиллая” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага суурь бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцагч бүрийн сурлагын чанарыг ахиулахын тулд суралцагчдыг оношлох, явцын болон үр дүнгийн, хөндлөнгийн үнэлгээг хийж үр дүнг тооцон ажиллах
- Багш бүр мэдлэг боловсролоо дээшлүүлэн багшийн ёс зүйг эрхэмлэн ажиллах

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд “1.ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, “2.Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр

дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,973.3 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	136,730.00	118,332.20	(18,397.80)
Бараа материал	80,623.30	105,845.70	25,222.40
Үндсэн хөрөнгө	1,586,044.50	1,606,193.00	20,148.50
Нийт хөрөнгө	1,803,397.80	1,830,371.10	26,973.30
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,803,397.80	1,830,371.10	26,973.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,803,397.80	1,830,371.10	26,973.30

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 118,332.3 мянган төгрөг болж 18,397.8 мянган төгрөгөөр буурсан нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9¹-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Бараа материал дансны үлдэгдэл 105,845.7 мянган төгрөг болж 25,222.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 135,266.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 17,656.1 мянган төгрөгийн хими, физикийн хэрэглэгдэхүүн, аймгийн БШУГ-аас 3,331.7 мянган төгрөгийн түрээсийн ном үнэ төлбөргүйгээр

¹ Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

хүлээн авсан, нийт 131,031.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,606,193.0 мянган төгрөг болж 20,148.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 48,717.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12,540.0 мянган төгрөгийн ширээ сандал, 7,401.7 мянган төгрөгийн хими, физикийн кабинетийн тоног төхөөрөмж, БШУЯ-аас 9,234.1 мянган төгрөгийн сурах бичиг, ААН-ийн хандиваар 2,375.0 мянган төгрөгийн ширээ сандал үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, нийт 60,119.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,207,665.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 189,399.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг **1,397,064.8** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 335,602.2 мянган төгрөгөөр, үдийн цайны зардлыг 20,822.6 мянган төгрөгөөр, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн зардлыг 380.1 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт төсвийг **1,754,069.7** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр **1,754,069.7** мянган төгрөгийн төсөв баталснаас 1,556,944.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 189,599.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 4,518.0 мянган төгрөгийг түрээсийн номын орлогоос, 3,007.8 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос урсгал үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,635,737.5** мянган төгрөг буюу 93.0 хувьтай тайлагнагдсан нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 89,285.6 мянган төгрөгөөр, үдийн цай, дотуур байрны үйлчилгээний зардал 24,684.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 4,362.4 мянган төгрөгөөр, мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

							/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь

1	71802 Ерөнхий боловсролын сургууль	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	4,406.90	4,406.90	-	100.0
		2	80312- Сургалт семинар	1,947.20	1,805.70	(141.50)	93.0
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	4,096.80	1,745.00	(2,351.80)	43.0
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	92,847.80	70,238.70	(22,609.10)	76.0
		5	81806- Дотуур байрны үйлчилгээ	43,360.00	41,284.90	(2,075.10)	95.0
		6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	41,200.20	39,972.00	(1,228.20)	97.0
		7	81823- Боловсролын багшийн сургалт	12,094.50	5,916.00	(6,178.50)	49.0
		8	81834- Боловсролын стандарт сургалт	1,102,937.30	1,026,868.00	(76,069.3)	93.0
		9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	247,561.30	240,523.50	(7,037.80)	97.0
		10	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	189,599.10	189,599.10	-	100.0
		11	81848-Сурах бичгийн түрээс	4,570.80	4,518.00	(52.80)	99.0
		12	83603-Нэмэлт төсвөөс хуваарилсан	3,007.80	3,007.80	-	100.0
		13	81827-Бичиг үсгийн боловсрол	6,440.00	5,851.90	(588.10)	91.0
Нийт				1,754,069.70	1,635,737.50	(118,332.20)	93.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт

санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ хүүхдийн хоолны зардал 136,207.8 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль гэх/ 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосонд хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Б.Ундаръяа гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,164,242.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,642.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, 17 мэдээллийг дутуу мэдээлсэн байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалт тендертэй холбоотой мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг 17 удаа дутуу мэдээлсэн.

Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Шинэ үерт” ХХК, “Мөнх Урагшлах Хүдэр ХХК, “Сод Хүдэр” ХХК-тай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмж өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас 1,092.7 мянган төгрөгийн цалин илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоож, нийгмийн даатгалын тайланд амралтын цалинг 6,831.9 мянган төгрөгөөр илүү тооцон тайлагнасан алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,092.7	1	1,092.7	100.0
Зөвлөмж	1	6,831.9	1	6,831.9	100.0
Нийт дүн	2	7,924.6	2	7,924.6	100.0

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд **“Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан”** гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Өмнөх онд албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт **1,982.0** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч З.Шинэхүүд 1,114.0 мянган төгрөг,
- Нярав Г.Амгаланбаярт 868.0 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт **18,011.3** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн санхүүжилтийг 4,302.6 мянган төгрөгөөр илүү, НД-аас орж ирсэн ХЧТА-ны тэтгэмжийн 190.7 мянган төгрөгийн орлогыг тусгасан байна.
- Түрээсийн номын орлого 4,518.0 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд огт тусгаагүй байна.
- Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 9,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй байна.

Аудитаар нийт **4,072.4** мянган төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан 32 багшид **4,072.4** мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орон нутгийн санхүүжилт илүү тусгасан	1	4,302.6			1	4,302.6	1	4,302.6				
Түрээсийн номын орлого тусгаагүй	1	4,518.0	1	4,518.0			1	4,518.0				
Хөрөнгө бүртгээгүй	1	9,000.0	1	9,000.0			1	9,000.0				
НД-аас санхүүжсан ХЧТАТэтгэмж санхүүгийн тайланд тусгасан	1	190.7			1	190.7	1	190.7				
Дүн	4	18,011.3	2	13,518.0	2	4,493.3	4	18,011.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Цалин илүү олгосон	1	4,072.4	1	4,072.4								
Дүн	1	4,072.4	1	4,072.4								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/							
			Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны 1 мэдээллийг хугацаа хоцроож, 17	1	-							1	-

мэдээллийг дутуу мэдээлсэн.								
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагаатай холбоотой	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Нийт дүн	2	-					2	-